

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНИЙ АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ, ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
БУЛГАНЫ НИНЖ-ЭРДЭНИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (Биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг хангана.”							
1.	Арга хэмжээ 1.1. Монгол Улсын хэмжээнд интернэтийн хаягжилтыг 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх ажлыг зохион байгуулна.	Интернэт хаягжилтын 6 дахь хувилбарт шилжсэн төрийн байгууллагуудын тоо	0	24	Үндэсний дата төв дээр байрлах Монголын интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдийн сүлжээ (MIX)-д Эрдэмнэт, Скаймедиа ХХК, Юнивишн ХХК, Жинэт ХХК, Мобиком нетворкс ХХК, Мобинэт ХХК, Ондо ХХК, Топика, МВС ХХК зэрэг интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг холбосон. Үндэсний дата төвийн үйлчилгээнд IPv6 технологийг нэвтрүүлж төрийн цахим хуудасны хостингийн системд байрших 1,327 төрийн байгууллагын цахим хуудсыг IPv6 хаягт бүрэн шилжүүлсэн. Түүнчлэн Үндэсний дата төвд байрших нийт сервер, тоног төхөөрөмж, зохиомол серверийг IPv6 хаяг шилжүүлэх дэд бүтцийг бий болгосон. Монгол Улсын гадаад гарцаар олон улс руу IPv6 хаягжилтаар гарч байгаа трафикийн хэмжээ 2024 оны 12 дугаар сарын байдлаар 43,35%-д хүрсэн.	09-12	100%

	Дэд арга хэмжээ – 1.1.1. Монгол Улсын хэмжээнд интернэтийн хаягжилтыг 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх талаар холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангах	Уулзалтын тоо	0	3	2024 оны 06 дугаар сарын 21-ны өдөр Үндэсний дата төвийн холбогдох албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, төрийн байгууллагуудын цахим хуудсыг IPv6 хувилбарт шилжүүлэх төлөвлөгөөний төсөл болон хэрэгжүлж буй арга хэмжээтэй танилцаж, санал өгсөн. Мөн Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл авахаар 2024 оны 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр уулзалт зохион байгуулсан.	09-12	100%
	Дэд арга хэмжээ – 1.1.2. Төрийн байгууллагуудыг интернэтийн хаягжилтыг 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Интернэт хаягжилтын 6 дахь хувилбарт шилжсэн төрийн байгууллагуудын тоо	0	24	Үндэсний дата төвийн үйлчилгээнд IPv6 технологийг нэвтрүүлж, төрийн цахим хуудасны хостингийн системд байрших 1,327 төрийн байгууллагын цахим хуудсыг IPv6 хаягт бүрэн шилжүүлсэн.	09-12	100%
Зорилт 2. “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, хяналт тавина”							
2.	Арга хэмжээ 2.2. Ашиглахгүй байгаа хуучин шилэн кабелийг сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулах, шилэн кабелийн сүлжээний багтаамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	Чөлөөлсөн болон шинээр суурилуулсан шилэн кабелийн урт (км)	45	90	2024 оны 05 дугаар сард Улаанбаатар хотын 4 чиглэлд 10423м, 06,07 дугаар саруудад 13 чиглэлд 10810.7м, 08 дугаар сард 4 чиглэлд 7763.6м, 09 дүгээр сард 4 чиглэлд 17257м, нийт 46253м физик кабелийг худаг сувагчлалаас чөлөөлж, худаг сувагчлалын багтаамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан.	01-12	100%
Зорилт 3. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар харилцаа холбооны сүлжээ өргөтгөх төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ”							
1.	Арга хэмжээ 3.1. Хүүхдэд ээлтэй "Итгэлтэй утас" төслийг орон даяар хэрэгжүүлэх ажлын тендер шалгаруулалтад орж ажиллана.	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	1	"Ерөнхий боловсролын сургууль, түүний орчимд бүх үүрэн телефоны дугаар руу үнэгүй залгах боломжтой Итгэлтэй утас буюу таксофон байршуулах" төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог ТНБД-ын 2024 оны	01-12	100%

					02 дугаар сарын 21-ний өдрийн А/38 дугаар тушаалаар байгуулсан. Нийт 908 ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр болон дотуур байрны судалгааг гаргаж, үүнээс Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн 181 цэг, 21 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрны 311 цэгт таксафон байрлуулах төлөвлөлтийг хийж, техникийн тодорхойлолтыг боловсруулсан. Тендер шалгаруулалтын талаарх танилцуулга болон Итгэлтэй утас байршуулах төлөвлөлтийг ТНБД-д 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр танилцуулсан.		
	Дэд арга хэмжээ – 3.1.1. Холбогдох судалгааг хийж техникийн тодорхойлолтыг боловсруулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	70%	Нийт 908 ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр болон дотуур байрны судалгааг гаргаж, үүнээс таксофон байрлуулах шаардлагатай Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн 181 цэг, 21 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрны 311 цэгийн төлөвлөлтийг хийж, техникийн тодорхойлолтыг боловсруулсан.	01-12	100%
	Дэд арга хэмжээ – 3.1.2. Үнэлгээний хороонд ажиллана.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	30%	"Ерөнхий боловсролын сургууль, түүний орчимд бүх үүрэн телефоны дугаар руу үнэгүй залгах боломжтой Итгэлтэй утас буюу таксафон байршуулах" төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог ТНБД-ын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/38	01-12	100%

					дугаар тушаалаар байгуулсан. Тендер шалгаруулалтын талаарх танилцуулга болон итгэлтэй утас байршуулах төлөвлөлтийг ТНБД-д 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр танилцуулсан.		
2	Арга хэмжээ 3.2. Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулна.	Тендерийн тоо	0	1	Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц /Улсын хэмжээнд/ төслийн хүрээнд нийт 100 цэгийн багцын задаргааг боловсруулж, Сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн А/10 тушаалаар батлуулсан. Төслийн тендер шалгаруулалт зохион байгуулах үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 09-ий өдрийн А/29 дугаар тушаалаар байгуулсан. Үнэлгээний хорооны хурлыг 2024 оны 02 дугаар сарын 21-ны өдөр зохион байгуулж, тендерийн бичиг баримтыг 2024 оны 02 сарын 29-ны өдөр батлуулсан. Тендерийн зарыг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр www.tender.gov.mn цахим системд байршуулсан. 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр тендерийн нээлт хийж, үнэлэн холбогдох мэдэгдлийг хүргүүлсэн. 1, 2, 3, 6 дугаар багцад санал ирүүлсэн оролцогч байхгүй, 4, 5, 7 дугаар багцад шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул эдгээр багцуудын тендер шалгаруулалт амжилтгүй болсон. Амжилтгүй болсон 7 багцад тендер ирүүлээгүй шалтгаан, нөхцөлийг судлан үзэхэд нэг багцад 2-3 аймаг хуваарилсан нь гүйцэтгэгч этгээдэд	01-04	100%

					тээврийн зардал өндөр гарч, төсөвт өртгөөс давсан байх үндэслэлтэй тул 11 багц байхаар шинэчлэн боловсруулж Сайдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/41 тушаалын хавсралтаар батлуулсан. Тендерийн баримт бичгийг шинэчлэн 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр батлуулж, www.tender.gov.mn цахим системд байршуулсан. 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр тендерийн нээлт хийж үнэлэн үнэлэн холбогдох мэдэгдлийг хүргүүлсэн.		
	Дэд арга хэмжээ – 3.2.1. Холбогдох судалгааг хийж техникийн тодорхойлолтыг боловсруулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	70%	Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц /Улсын хэмжээнд/ төслийн хүрээнд нийт 100 цэгийн багцын задаргааг боловсруулж, сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн А/10 тушаалаар батлуулсан. 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдөр зарласан тендер шалгаруулалтаар Амжилтгүй болсон 7 багцад тендер ирүүлээгүй шалтгаан, нөхцөлийг судлан үзэхэд нэг багцад 2-3 аймаг хуваарилсан нь гүйцэтгэгч этгээдэд тээврийн зардал өндөр гарч, төсөвт өртгөөс давсан байх үндэслэлтэй тул 11 багц байхаар шинэчлэн боловсруулж Сайдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/41 тушаалын хавсралтаар батлуулсан. Тендерийн баримт бичгийг шинэчлэн 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр батлуулж, www.tender.gov.mn цахим системд байршуулсан. 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр тендерийн	01-04	100%

					нээлт хийж үнэлэн үнэлэн холбогдох мэдэгдлийг хүргүүлсэн.		
	Дэд арга хэмжээ – 3.2.2. Тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороонд ажиллана.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	30%	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх “Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц” /Улсын хэмжээнд/ төслийн тендер шалгаруулалт зохион байгуулах үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 09-ий өдрийн А29 дугаар тушаалаар байгуулсан. Үнэлгээний хорооны хурлыг 2024 оны 02 дугаар сарын 21-ны өдөр зохион байгуулж, тендерийн бичиг баримтыг 2024 оны 02 сарын 29-ны өдөр батлуулсан. Тендерийн зарыг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр www.tender.gov.mn цахим системд байршуулсан. 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр тендерийн нээлт хийж үнэлэн холбогдох мэдэгдлийг хүргүүлсэн. 1, 2, 3, 6 дугаар багцад санал ирүүлсэн оролцогч байхгүй, 4, 5, 7 дугаар багцад шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул эдгээр багцуудын тендер шалгаруулалт амжилтгүй болсон. Тендерийн баримт бичгийг шинэчлэн 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр батлуулж, www.tender.gov.mn цахим системд байршуулсан. 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр тендерийн нээлт хийж үнэлэн үнэлэн холбогдох мэдэгдлийг хүргүүлсэн.	01-04	100%

Зорилт 4. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд харилцаа холбооны сүлжээ өргөтгөх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, хүлээн авна”

1.	Арга хэмжээ 4.1. Улсын төсөв, БНҮҮС хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх харилцаа холбооны сүлжээ өргөтгөх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавих. ашиглалтад хүлээн авна. /Улсын хэмжээнд/	Ашиглалтад орсон станцын тоо	-	59	Зураг төсөв батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй байсны улмаас орон нутгийн ЗДТГ-аас ажил эхлүүлэх зөвшөөрөл олгогдоогүй тул Улсын комисс ажиллаагүй.	07-12	-
2.	Арга хэмжээ 4.2. Хүүхдэд ээлтэй "Итгэлтэй утас" төслийн гүйцэтгэлийг хянах, ашиглалтад хүлээн авна.	Итгэлтэй утас суурилуулсан цэгийн тоо	-	300	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/166 тушаалаар батлагдсан Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Худалдан авах ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөнөөс уг төслийг хассан тул хэрэгжээгүй.	07-12	-
Зорилт 5. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"							
1.	Арга хэмжээ 5.1. Яамны дотоод болон бусад байгууллагаас байгуулсан ажлын хэсэг, үнэлгээний хороонд орж ажиллах	Ажлын хэсгийн тоо	-	2	ТНБД-ийн 2024 оны 02 дугаар сарын 09-ий өдрийн А/29 дугаар тушаалаар байгуулсан Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц /Улсын хэмжээнд/ төслийн тендер шалгаруулалтын зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооны гишүүн, ТНБД-ийн 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тушаалаар уг үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар, ТНБД-ын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/38 дугаар тушаалаар байгуулагдсан "Ерөнхий боловсролын сургууль, түүний орчимд бүх үүрэн телефоны дугаар руу үнэгүй залгах боломжтой Итгэлтэй утас буюу таксофон байршуулах" төслийн тендер	01-12	100%

					шалгаруулалтын зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар, 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/30 дугаар тушаалаар байгуулагдсан Интернэтийн дундын холболтын журам боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн гишүүнээр тс тус ажилласан.		
2.	Арга хэмжээ 5.2. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	ХАСХОМ бөглөх болон хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан баримтын тоо	0%	100%	- 2023 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө оруулгын мэдүүлгийг 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдөр гаргасан. - Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц /Улсын хэмжээнд/ төслийн тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд ажиллахад ашиг сонирхлын мэдүүлгийн 2024 оны 02 дугаар сарын 09-ны өдөр гаргасан. - "Ерөнхий боловсролын сургууль, түүний орчимд бүх үүрэн телефоны дугаар руу үнэгүй залгах боломжтой Итгэлтэй утас буюу таксофон байршуулах" төслийн тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд ажиллахад ашиг сонирхлын мэдүүлгийн 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр гаргасан.	01-12	100%
3.	Арга хэмжээ 5.3. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнах	Төлөвлөгөөний тоо	1	1	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулсан газрын даргаар батлуулсан.	01-12	100%
		Тайлангийн тоо	0	2	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны эхний хагас жил болон жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг гаргасан.	01-12	100%

4.	Арга хэмжээ 5.4. Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Хэрэгжилтийн тайлан хүргүүлсэн эсэх	0	Тухай бүр	- Монгол Улсын нутаг дэвсгэрийн хүрээнд үүрэн холбооны сүлжээний тархалтын судалгааг хийж Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. - Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон Аймаг, нийслэлийн засаг дарга хооронд 2024 онд хамтран ажиллах гэрээний төсөлд харилцаа холбооны дэд бүтцийг нэмэгдүүлэх чиглэлээр саналыг боловсруулж өгсөн. - “Цахим хэвшье” арга хэмжээний хүрээнд 21 аймгийн харилцаа холбооны үзүүлэлт, Улсын төсөв болон бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн мэдээллийг бэлтгэж, тухай бүр дэд сайдын илтгэлд оруулсан. - 1 дүгээр улирлын газрын 7 хоног, сар, 1 дүгээр улирал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомжийн хэрэгжилт, 2022-2023 оны Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг цаг хугацаанд чанартай нь гаргаж ТЗУГ-т хүргүүлсэн. - 2025 оны Улсын төсвийн санал Алслагдсан багуудад харилцаа холбооны дэд бүтэц, дахин дамжуулах станц байгуулах төсөл /60 цэг/ төслийн танилцуулгыг боловсруулж, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн. - 2024-2028 оны ЗГҮАХ-т санал өгч, БТГ-т хүргүүлсэн.	01-12	100%
----	---	--	---	-----------	--	-------	------

					- “Шинэ хархорум” хотын эхний ээлжийн “өндөр ордон”-ы ажлын зураг төсөл боловсруулах даалгаврийг боловсруулж Ерөнхийлөгчийн тамгын газарт 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр хүргүүлсэн. - Шинэ Хархорум хотын эхний ээлжийн мэдээлэл, харилцаа холбооны худаг, сувагчлал, шилэн кабелийн ажлын зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 2024/02 дугаар бүхий ажлын даалгаврыг батлуулсан. - Харилцаа холбооны сүлжээний нэгдсэн хяналтын самбар /Дашбоард/ хийхэд И-Монголиа УТҮГ-д дэмжлэг үзүүлэн ажилласан. - 2025 онд харилцаа холбооны сүлжээг өргөтгөх сайтын судалгааг газрын бусад албан хаагчдын хамт хийсэн.		
5.	Арга хэмжээ 5.5. Байгууллагуудаас ирүүлсэн албан бичигтэй тухай бүрд нь танилцаж, хариу хүргүүлэх	Албан бичигт тухай бүрд нь хариу хүргүүлсэн эсэх	0	Тухай бүр	Ирсэн бичиг: 83 Явсан бичиг: 83	01-12	100%

6.	Арга хэмжээ 5.6. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх	шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн тоо	0	Тухай бүр	Тайлант хугацаанд өргөдөл цохогдоогүй.	01-12	100%
7.	Арга хэмжээ 5.7. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлах	Архивд хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо	0	Тухай бүр	ЦХХХЯ-ны 2023 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн холбогдох 1 боть материал, 2024 оны Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төслийн холбогдох 27 боть материалыг тус тус архивласан.	01-12	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдах.	Сургалт, семинарт хамрагдсан байна	0	1	Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан Төрийн албаны хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2024 оны 01-р сарын 30-ний өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдөр хамрагдаж, №2061 сертификат авсан.	01-12	100%

2.	Арга хэмжээ 2. Хариуцсан ажлын чиглэлээр хууль, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх ном, гарын авлага, туршлага судлах.	Салбарын шинээр гарсан хууль, тогтоомж, холбогдох ном, гарын авлага, туршлага судалсан байна	0	1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан уг хууль болон дагаж гарсан холбогдох журмуудыг судалсан.	01-12	100%
----	--	--	---	---	--	-------	------

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХХБХЗГ-ын ахлах мэргэжилтэн

(Албан тушаал)

Б.Нинж-Эрдэнэ /  /

(Нэр, гарын үсэг)

2024 12 05

(Огноо)